



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 12 дугаар сарын 23
№50 (1248)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

965. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай 3588

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

966. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай Дугаар 78 3589

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

967. Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 212 3590

968. Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 213 3590

969. Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 214 3591

970. Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 215 3591

971. Шүүгчийн албан тушаалаас
чөлөөлөх тухай Дугаар 216 3592

972. Шүүгчийн албан тушаалаас
чөлөөлөх тухай Дугаар 217 3592

973. Албан тушаалд томилох тухай Дугаар 227 3593

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

974. Дүрэм шинэчлэн батлах тухай Дугаар 266 3593

975. Журам батлах тухай Дугаар 268 3601

976. Журам батлах тухай Дугаар 269 3604

977. Журам батлах тухай Дугаар 291 3608

978. Журам шинэчлэн батлах тухай Дугаар 296 3612



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 дүгээр
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 51.3 дахь хэсэг нэмсүгэй:

“51.3.Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Хуульчилж
сэвсгэр
сүлжээ

Хуульчилж сэвсгэр сүлжээний үндсэн дээр 2022 оны 11 сарын 11-ний өдөр баталсан хууль

Хуульчилж сэвсгэр сүлжээний үндсэн дээр 2022 оны 11 сарын 11-ний өдөр баталсан хууль

6-р хуульчилж сэвсгэр сүлжээний үндсэн дээр 2022 оны 11 сарын 11-ний өдөр баталсан хууль

«61.3. Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.»

7-р хуульчилж сэвсгэр сүлжээний үндсэн дээр 2022 оны 11 сарын 11-ний өдөр баталсан хууль

Хуульчилж сэвсгэр сүлжээний үндсэн дээр 2022 оны 11 сарын 11-ний өдөр баталсан хууль



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 78

Улаанбаатар
хот

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшинг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны, Ширнэнбаньдын Адьшааг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшинг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр баталсугай.

3.Энэ тогтоолыг 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Зөвшөөрч
Хуульчилж
Харгалж
Хүндэтгэж
Хураарх

2022 оны 12 сарын 09 - өдөр
Монгол Улсын Их Хурлын дарга
Г.Занданшатар

Хуульчилж
Харгалж
Хүндэтгэж
Хураарх

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшинг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.
2. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшинг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр баталсугай.
3. Энэ тогтоолыг 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

6. Өмнөх тус тусын тухай хуулийн 8.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшинг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны, Ширнэнбаньдын Адьшааг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.
2. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшинг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр баталсугай.
3. Энэ тогтоолыг 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

10. Өмнөх тус тусын тухай хуулийн 8.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Зөвшөөрч
Хуульчилж
Харгалж
Хүндэтгэж
Хураарх



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 212

Улаанбаатар
хот

Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 308 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1.Төмөрбаатарын Бадрахыг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2.Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Төмөрбаатарын Бадрахыг Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 213

Улаанбаатар
хот

Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 310 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1.Дашдоржийн Золзаяаг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2.Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Дашдоржийн Золзаяаг Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 214

Улаанбаатар
хот

Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 309 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1.Эрдэнэчимэгийн Энэбишийг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2.Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Эрдэнэчимэгийн Энэбишийг Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 215

Улаанбаатар
хот

Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 311 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1.Зоригтын Түвшинтөгсийг Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2.Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Зоригтын Түвшинтөгсийг Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 11 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 216

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.9 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 305 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн Маруушийн Хүрэлбаатарыг Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 11 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 217

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 315 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Азүйсэдийн Мөнхзулыг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 11 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 227

Улаанбаатар
хот

Албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Жаргалсайханы Өсөхбаярыг Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 266

Улаанбаатар
хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын дэргэд ажиллах нэг талаас ажил олгогч, даатгуулагч, нөгөө талаас нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрөөг хянаж шийдвэрлэх “Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэм”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрмийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Зоригт)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяад тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 1994 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 171 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

А.АРИУНЗАЯА

Засгийн газрын 2022 оны 266 дугаар
тогтоолын хавсралт

ГОМДЛЫН ШААРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмийн зорилго нь нэг талаас ажил олгогч, даатгуулагч, нөгөө талаас нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрөөг хянаж шийдвэрлэх Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гомдлын шаардлагын зөвлөл (орон тооны бус)-ийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Гомдлын шаардлагын төв зөвлөл (цаашид “Төв зөвлөл” гэх) нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд, гомдлын шаардлагын салбар зөвлөл (цаашид “Салбар зөвлөл” гэх) аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын дэргэд тус тус ажиллана.

1.3.Төв зөвлөл нь салбар зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах бөгөөд салбар зөвлөл үйл ажиллагаагаа төв зөвлөлд, төв зөвлөл үйл ажиллагаагаа нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус тус тайлагнана.

1.4.Төв болон салбар зөвлөл нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ажил олгогч, даатгуулагчийн болон нийгмийн даатгалын байгууллагын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, ажил олгогч, даатгуулагчийн нууцыг чанд хадгалах зарчмыг баримталж, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.5.Энэ дүрмийн 1.1-д заасан саналын зөрөө (цаашид “Гомдол” гэх)-г шийдвэрлүүлэхээр гомдол гаргах этгээд (цаашид “Гомдол гаргагч” гэх) нь гомдлоо харьяалах нийгмийн даатгалын байгууллагын дэргэдэх салбар зөвлөлд, салбар зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл төв зөвлөлд тус тус гаргана.

1.6.Төв болон салбар зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.



Хоёр.Төв болон салбар зөвлөлийн бүрэлдэхүүн

2.1.Төв зөвлөл нь дарга, гишүүдээс бүрдсэн 7 хүний, салбар зөвлөл нь дарга, гишүүдээс бүрдсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.2.Төв зөвлөлийн дарга нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нийгмийн даатгалын хууль тогтоомжийн бодлогын хэрэгжилт, эсхүл дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн дарга, гишүүд нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл 3, мэргэжлийн хяналтын төв байгууллагын төлөөлөл 2, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл 1 байна.

2.3.Салбар зөвлөлийн дарга нь тухайн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын дарга, гишүүд нь тухайн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын төлөөлөл 2, мэргэжлийн хяналтын газрын төлөөлөл 1, хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл 1 байна.

2.4.Төв болон салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батлах бөгөөд төв зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлахдаа мэргэжлийн хяналтын төв болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагын, салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлахдаа тухайн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага, мэргэжлийн хяналтын газар болон хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагын саналыг тус тус үндэслэн батална.

2.5.Төв болон салбар зөвлөлийн гишүүнийг 3 жилийн хугацаагаар томилох бөгөөд ажлын үр дүнг харгалзан үзэж хугацааг 1 жилээр сунгаж болно.

2.6.Төв болон салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд энэ дүрмийн 2.4-т заасан байгууллагын саналыг үндэслэн өөрчлөлт оруулж болно.

2.7.Төв зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хууль, эрх зүйн, эсхүл хяналт, шалгалтын асуудал хариуцсан ажилтан, салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг тухайн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын хууль, эрх зүйн, эсхүл хяналт, шалгалтын асуудал хариуцсан ажилтан тус тус гүйцэтгэнэ.

Гурав.Төв болон салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр, хэрэгжүүлэх чиг үүрэг

3.1.Төв болон салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан (цаашид “Хуралдаан” гэх) байна.

3.2.Төв болон салбар зөвлөл нь сард нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд тухай бүр хуралдана. Хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

3.3.Хуралдаанаар энэ дүрмийн 1.5-д заасны дагуу гаргасан гомдлыг хянаж шийдвэрлэх бөгөөд гомдол гаргагч гомдлоо бичгээр, эсхүл цахимаар гаргана. Гомдол дараах шаардлагыг хангасан байна:

3.3.1.гомдолд гомдол гаргагч өөрийн овог, нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаараа бичсэн байх;

3.3.2.гарын үсгээ зурсан, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан байх.

3.4.Төв болон салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга гомдлыг хүлээн авч ажлын нэг өдөрт багтаан бүртгэж, тухайн зөвлөлийн даргад тухай бүр хүргүүлэх бөгөөд төв болон салбар зөвлөл нь энэ дүрмийн 3.5-д заасны дагуу буцааснаас бусад тохиолдолд гомдлыг 30 хоногт багтаан хянаж шийдвэрлэнэ.

3.5.Төв болон салбар зөвлөлийн дарга энэ дүрмийн 1.5-д заасны дагуу гаргаагүй, эсхүл мөн дүрмийн 3.3-т заасан шаардлагыг хангаагүй гомдлыг гомдол гаргагчид 3 хоногийн дотор буцаах буюу мөн хугацаанд багтаан шаардлагыг хангуулах арга хэмжээ авна. Гомдлыг буцаахдаа буцааж байгаа үндэслэл, шалтгааныг тодорхой заасан байна.

3.6.Хуралдаанаар хэлэлцэх гомдлын жагсаалт болон бүрдэл, хуралдаан болох газар, товыг тухайн зөвлөлийн дарга, түүний эзгүйд тухайн зөвлөлийн даргын сонгосон гишүүн баталгаажуулна.

3.7.Төв болон салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь энэ дүрмийн 3.6-д заасан материалыг хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө тухайн зөвлөлийн гишүүдэд хүргүүлж, хуралдаан болох газар, товын талаарх мэдээллийг гомдол гаргагчид мэдэгдэнэ.

3.8.Хуралдаан тухайн зөвлөлийн бүрэлдэхүүний дийлэнх олонх оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцогдоно. Хуралдаанд тухайн



зөвлөлийн аль нэг гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас цахим хэлбэрээр оролцохоор бол ажлын 1-ээс доошгүй өдрийн өмнө нарийн бичгийн даргад энэ талаар мэдэгдэнэ.

3.9.Хуралдаанд гомдол гаргагчийг хүсэлтийнх нь дагуу оролцуулж болно. Мөн гомдолд холбогдох байгууллагын ажилтныг зөвлөлийн хуралдаанд оролцуулж болно.

3.10.Хуралдааныг тухайн зөвлөлийн дарга, түүний эзгүйд энэ дүрмийн 3.6-д заасан гишүүн удирдана.

3.11.Төв болон салбар зөвлөлийн хуралдаанаас тогтоол, тэмдэглэл гаргана. Хуралдааны шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар гаргана.

3.12.Хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын талаар тогтоол гаргах бөгөөд тухайн зөвлөлийн нарийн бичгийн дарга ажлын 3 хоногт багтаан эцсийн томъёоллыг хийж, тухайн зөвлөлийн дарга хянасны үндсэн дээр гарын үсгээ зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

3.13.Хуралдааны тэмдэглэлийг тухайн зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлж, ажлын 3 хоногт багтаан албажуулна. Хуралдааны тэмдэглэлд тухайн зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна. Хуралдааны шийдвэртэй саналын зөрүүтэй байгаа гишүүн өөрийн саналыг хуралдааны тэмдэглэлд бичүүлэх буюу саналаа бичгээр гаргаж хуралдааны баримт бичигт хавсаргаж болно.

3.14.Төв болон салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хуралдааны шийдвэрийг баталгаажуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор гомдол гаргагчид хүргүүлж, танилцуулна.

3.15.Төв болон салбар зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сайтар судалж хэрэгжилтийг хангуулах, гарсан шийдвэрийнхээ үндэслэлийг гомдол гаргагчид тайлбарлах, ойлгуулах, асуудлыг бусдын нөлөөнд үл автах зарчим баримтлан шударгаар шийдвэрлэнэ.

3.16.Төв болон салбар зөвлөлийн дарга, гишүүн нь гомдол гаргагчийн төрөл садан, хамаарал бүхий этгээд байвал уг гомдлыг хэлэлцэхээс татгалзна.

3.17.Төв зөвлөл гомдол гаргагчийн гомдол хууль зүйн үндэслэлтэй гэж үзвэл салбар зөвлөлийн шийдвэрийг өөрчлөх, хэвээр үлдээх, эсхүл хүчингүй болгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Дөрөв.Талуудын эрх, үүрэг

4.1.Ажил олгогч, даатгуулагч дор дурдсан эрх, үүрэгтэй байна:

4.1.1.ажил олгогч, даатгуулагч нь нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гомдлоо энэ дүрмийн 1.5-д заасны дагуу гаргах;

4.1.2.гарсан гомдолтой холбогдох акт, баримт бичигтэй танилцах;

4.1.3.төв болон салбар зөвлөлийн хуралдаанд биечлэн оролцож санал, хүсэлтээ гаргах;

4.1.4.төв болон салбар зөвлөлийн хуралдаан болохоос өмнө гомдлын талаар амаар буюу бичгээр тайлбар, тодорхойлолт гаргаж өгөх;

4.1.5.төв болон салбар зөвлөлийн хуралдааны тогтоол, тэмдэглэлтэй танилцах;

4.1.6.төв зөвлөлийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл шүүхэд гомдлоо гаргах;

4.1.7.төв болон салбар зөвлөлийн дарга, гишүүдийн аль нэг нь шалгагч, гомдол гаргагчийн төрөл садан, эсхүл уг гомдлын талаар шалгаж байсан бол түүгээр гомдлыг шалгаж шийдвэрлүүлэхээс татгалзах;

4.1.8.төв болон салбар зөвлөлийн хянан хэлэлцэж байгаа гомдлын талаар нотлох баримт, шаардлагатай тайлбар, тодорхойлолтыг тухайн зөвлөлийн дарга, гишүүдэд гаргаж өгөх.

4.2.Төв болон салбар зөвлөл нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна:

4.2.1.гомдлыг шийдвэрлэхэд шаардлагатай баримт бичиг, мэдээ, судалгааг холбогдох ажил олгогч болон даатгуулагч, даатгагчаас гаргуулж авах;

4.2.2.гомдол гаргагч болон холбогдох байгууллага, иргэдээс тайлбар, тодорхойлолт гаргуулж авах, санал, хүсэлтийг нь сонсох, мэргэжилтэн урьж зөвлөгөө авах;

4.2.3.нийгмийн даатгалын байгууллагын болон байцаагчийн шийдвэрийг хууль зүйн үндэслэлтэй гэж үзвэл ажил олгогч,



даатгуулагчийн гомдлыг хэрэгсэхгүй болгоно. Хэрэв гомдол гаргагчийн гомдол нь хууль зүйн үндэслэлтэй нь нотлогдвол буруу тогтоож олгосон тэтгэвэр, тэтгэмжийг шинэчлэх, гаргасан зардлыг нь олгуулах асуудлыг нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагад тавих;

4.2.4.тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн эрх үүсэх үндсэн нөхцөл, болзол болон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн хэмжээний талаар гарсан гомдлыг холбогдох баримт бичгийг үндэслэн зохих хууль тогтоомжид нийцүүлэн хянаж шийдвэрлэх;

4.2.5.тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг нөхөн олгох, түдгэлзүүлэх, зогсоох, ажил олгогч, даатгуулагчийн буруутай үйл ажиллагаанаас болон хуурамч баримт бичиг бүрдүүлснээс шалтгаалан буруу тогтоогдсон тэтгэвэр, тэтгэмжийг өөрчлөн тогтоож олгох, суутгал хийх;

4.2.6.хөдөлмөрийн болон даатгалын дэвтэр нь зохих журмын дагуу хөтлөгдөөгүй тохиолдолд нотлох баримтыг хянаж түүний ажилласан хугацаа, төлсөн шимтгэлийн хэмжээг тогтоох;

4.2.7.гомдол гаргагчаас гаргасан гомдолтой нь холбогдуулан буцааж өгөхөөр авсан баримт бичгийг шийдвэр гарсны дараа нэн даруй эргүүлж өгөх, хувийг хуулбарлаж холбогдох баримт бичигт хавсаргах;

4.2.8.төв болон салбар зөвлөлөөр хэлэлцэж байгаа асуудал гэмт хэргийн шинжтэй бол хууль тогтоомжид заасны дагуу холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэх.

Тав.Мэдээллийн сан

5.1.Төв болон салбар зөвлөл нь үйл ажиллагаандаа ашиглах гомдлын шаардлагын зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сан (цаашид “Мэдээллийн сан” гэх)-тай байна.

5.2.Мэдээллийн сан нь төв болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах, ил тод болгох, үйл ажиллагаанд хяналт тавих, судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан, мэдээ гаргах, хяналт шалгалт хийх боломжийг бүрдүүлсэн байна.

5.3.Мэдээллийн санд төв болон салбар зөвлөлөөс гаргасан бүх шийдвэрийг бүртгэж, хөтөлнө.



5.4.Мэдээллийн санд ажил олгогч, даатгуулагчийн дор дурдсан мэдээллийг тусгана:

5.4.1.ажил олгогчийн нэр, регистрийн дугаар, нийгмийн даатгалын дугаар, хаяг, цахим шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаар, шаардлагатай үед холбоо барих хүний холбогдох мэдээлэл;

5.4.2.даатгуулагчийн овог, нэр, хаяг, харьяалал, холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаяг, шаардлагатай үед холбоо барих хүний утасны дугаар;

5.4.3.төв болон салбар зөвлөлд хандан гаргасан гомдолтой холбоотой баримт бичиг болон бусад нотлох баримт бичиг.

5.5.Гомдол гаргагч өөрт хамаарал бүхий мэдээллийг мэдээллийн сангаас авч болно.

5.6.Төв болон салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь тухайн зөвлөлийн шийдвэрийг тухай бүр мэдээллийн санд оруулж, үнэн зөв байдлыг хариуцах бөгөөд бусад шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авч оруулж болно.

5.7.Төв болон салбар зөвлөл нь энэ дүрмийн 5.4, 5.6-д заасан мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

Зургаа.Бусад

6.1.Энэ дүрмийн 2.2-т заасан мэргэжлийн хяналтын төв болон мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл, 2.3-т заасан аймаг, дүүргийн мэргэжлийн хяналтын газрын болон хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагын төлөөлөлд хуралдаанд оролцсон цаг, ажлын үр дүнг нь үндэслэн урамшуулал олгож болно.

6.2.Энэ дүрмийн 6.1-д заасан урамшууллыг цагаар тооцож олгох бөгөөд Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооноос баталсан хөдөлмөрийн хөлсний нэг цагийн доод хэмжээг дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

6.3.Урамшууллын эх үүсвэрийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын болон холбогдох аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын жил бүрийн үйл ажиллагааны зардалд тооцож тусгасны үндсэн дээр зохих журмын дагуу санхүүжүүлэх арга хэмжээ авна.



6.4.Төв болон салбар зөвлөлийн гишүүн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3-аас дээш удаа оролцоогүй бол энэ дүрмийн 2.6-д заасны дагуу чөлөөлнө.

6.5.Төв болон салбар зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга хууль тогтоомж зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 268

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Музейн тухай хуулийн 15.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Мөнгөн урамшуулалд энэ онд шаардагдах хөрөнгийг 2022 оны батлагдсан төсөвтөө багтааж, цаашид жил бүрийн төсвийн төсөлдөө тусган санхүүжүүлж байхыг Соёлын сайд Ч.Номин, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

СОЁЛЫН САЙД

Ч.НОМИН

Засгийн газрын 2022 оны 268 дугаар
тогтоолын хавсралт

МУЗЕЙН ҮЗМЭРТЭЙ ШУУД ХАРЬЦАХ АЛБАН ТУШААЛТАНД МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Музейн тухай хуулийн 15.3-т заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн музей (цаашид “Музей” гэх)-н үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд найман жил тутам нэг жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоход энэ журмыг мөрдөнө.

1.2.Мөнгөн урамшууллын хэмжээ музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтны сүүлийн нэг жилийн үндсэн цалинтай тэнцүү байна.

Хоёр.Мөнгөн урамшуулал олгоход тавигдах шаардлага

2.1.Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтан музейд орон тооны үндсэн ажилтнаар томилогдсоноос хойш тасралтгүй найман жил (96 сар) ажилласан нөхцөлд мөнгөн урамшуулал авах эрх үүснэ.

2.2.Энэ журмын 2.1-д заасан хугацаанд дараах нөхцөлийг хамааруулж тооцно:

2.2.1.жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхдээ асрах чөлөөтэй байсан хугацаа;

2.2.2.хугацаат цэргийн алба хаасан хугацаа;

2.2.3.ажлаас үндэслэлгүйгээр халагдсаныг шүүхээс эгүүлэн тогтоосон бол уг шалтгаанаар ажилгүй байсан хугацаа;

2.2.4.баривчлагдсан буюу цагдан хоригдсон ажилтан гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс суллагдсан, шүүхээс цагаатгах тогтоол гаргасан, гэмт хэргийн шинжгүйн улмаас эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон хугацаа;

2.2.5.музейн захиалгаар дотоод, гадаадад зургаан сар хүртэл хугацаагаар давтан болон мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэхээр суралцсан хугацаа;

2.2.6.эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн тогтоолыг хүчингүй болгосон бол албан тушаалтныг ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан хугацаа;

2.2.7.зайлшгүй дэргэд нь байж асрах шаардлагатай гэр бүлийн гишүүнийг гурав хүртэл сараар сахиж, асарсан хугацаа;

2.2.8.эрүүл мэндийн шалтгааны улмаас гурав хүртэл сараар эмчлүүлсэн хугацаа;

2.2.9.гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтын бүсэд дайчлагдан ажилласан хугацаа;



2.2.10.музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалд дагалданаар болон туршилтаар ажилласан хугацаа.

2.3.Энэ журмын 2.2-т заасан нөхцөлд хамааруулж тооцох нийт хугацаа 36 сараас хэтрэхгүй байна.

2.4.Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтнаар ажиллах хугацаандаа музей дотроо, эсхүл музей хооронд уг албан тушаалд шилжин болон сэлгэн ажилласныг тасралтгүй ажилласанд тооцно.

2.5.Дараах нөхцөлд мөнгөн урамшуулал олгохгүй:

2.5.1.энэ журмын 2.1-д заасны дагуу музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалд ажилласан хугацаа хүрээгүй;

2.5.2.2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан;

2.5.3.албан тушаалтны ажлын гүйцэтгэл 3, түүнээс дээш жил хангалтгүй үнэлэгдсэн.

Гурав.Мөнгөн урамшуулал олгох

3.1.Музейн хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж, эсхүл албан тушаалтан жил бүрийн 6 дугаар сард багтаан үзмэртэй шууд харьцах албан тушаалтны тасралтгүй ажилласан жилийг тооцож, музейн захиралд танилцуулна.

3.2.Музейн захирал дараа онд мөнгөн урамшуулал авах эрх үүсэх албан тушаалтанд мөнгөн урамшуулал олгоход шаардагдах зардлыг байгууллагын төсвийн төсөлд тусган батлуулах арга хэмжээ авна.

3.3.Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтан энэ журмын 2.1-д заасан эрх үүсмэгц мөнгөн урамшуулал авах хүсэлтээ музейн захиралд гаргана.

3.4.Музейн захирал үзмэртэй шууд харьцах албан тушаалтны хүсэлтийг хүлээн авч, хянан үзээд ажлын 14 өдөрт багтаан мөнгөн урамшуулал олгох шийдвэр гаргана.

3.5.Хуульд зааснаас бусад тохиолдолд мөнгөн урамшууллаас татвар, шимтгэл, суутгал, хураамж авах, эсхүл аливаа биет (бараа, материал гэх мэт) болон биет бус (аяллын эрх, үзвэрийн билет гэх мэт) хэлбэрээр орлуулж олгохыг хориглоно.



3.6.Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтны тасралтгүй ажилласан хугацааг тооцохдоо тухайн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа, ажилд томилсон тушаал болон холбогдох бусад баримт бичгийг үндэслэнэ.

3.7.2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө найм ба түүнээс дээш жил музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалд ажилласан ажилтанд энэ журмын 1.2-т заасны дагуу мөнгөн урамшуулал олгоно.

Дөрөв. Бусад

4.1.Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд мөнгөн урамшуулал давтан олгох хугацааг энэ журмын 2.1-д заасан эрх үүссэн өдрөөс эхлэн тооцно.

4.2.Энэ журмын 3.7-д заасан албан тушаалтанд мөнгөн урамшуулал давтан олгох хугацааг мөнгөн урамшуулал олгосон өдрөөс эхлэн тооцно.

4.3.Энэ журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцно.

---оОо---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 269

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

СОЁЛЫН САЙД

Ч.НОМИН

Засгийн газрын 2022 оны 269 дүгээр
тогтоолын хавсралт

**ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ ХОСГҮЙ ҮНЭТ
ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ,
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл (цаашид “Дурсгалт зүйл” гэх)-ийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Зөвхөн Монгол Улсын иргэн, хуулийн этгээд нь дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлнэ.

1.3.Эх төрх, бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны хувьд хосгүй гайхамшигт үнэ цэнэ, ач холбогдолтой, ур хийцийн хувьд дахин давтагдашгүй байх нөхцөл нь хосгүй үнэт дурсгалт зүйлийн үндсэн шалгуур болно.

**Хоёр.Хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд
нэр дэвшүүлэх**

2.1.Хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх дурсгалт зүйл нь дараах шаардлагад нийцсэн байна:

2.1.1.эх хувь байх;

2.1.2.тухайн төрлийн дурсгалт зүйлийн сонгодог төлөөлөл байх;

2.1.3.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний язгуур эрх ашигт харшлахгүй байх;

2.1.4.өмчлөлийн маргаангүй байх;

2.1.5.судалгаа шинжилгээний эргэлтэд орсон, олон нийтэд танигдсан байх;

2.1.6.түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлтэй байх.

2.2.Монгол Улсын түүхэнд гарамгай гавьяа байгуулсан төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, урлаг, соёлын алдартан зэрэг гавьяат үйлстэнд зориулан төрөөс тусгайлан захиалж, үйлдвэрийн аргаар бүтээлгэсэн дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлж болно.

2.3.Энэ журмын 2.1, 2.2-т зааснаас бусад үйлдвэрийн аргаар ижил хэлбэр, хэмжээтэй бүтээсэн дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэхгүй.

2.4.Энэ журмын 2.1, 2.2-т заасан шаардлага хангасан эсэхийг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд байгаа мэдээлэлд үндэслэн тодорхойлно.

2.5.Энэ журмын 2.1, 2.2-т заасан шаардлагыг хангасан дурсгалт зүйлийн өмчлөгч, эзэмшигч нь хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх саналаа дор дурдсан баримт бичгийн хамт Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлнэ:

2.5.1.дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх саналаа илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, эсхүл албан бичиг;

2.5.2.энэ журмын 2.1, 2.2-т заасан шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

2.5.3.түүх, соёл, урлаг судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрдэм шинжилгээний байгууллагын тодорхойлолт;

2.5.4.дурсгалт зүйлийн гэрэл зураг, дүрс бичлэг, холбогдох бусад зүйл.

2.6.Соёлын өвийн үндэсний төв энэ журмын 2.5-д заасан баримт бичгийн бүрдлийг хянаж, хүлээн авна. Баримт бичгийн бүрдэл дутуу бол дурсгалт зүйлийн өмчлөгч, эзэмшигчид буцаана.

2.7.Соёлын өвийн үндэсний төв шаардлагатай бол холбогдох байгууллагаас нэмэлт мэдээлэл, тодруулга, лавлагаа авч болно.

Гурав.Саналыг хянах

3.1.Соёлын өвийн үндэсний төвийн захирлын шийдвэрээр томилогдсон шинжээчийн комисс хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлсэн дурсгалт зүйлийг энэ журмын холбогдох шаардлагыг хангасан эсэх талаар дүгнэлт гаргана. Шинжээчийн комиссын бүрэлдэхүүнд нэр дэвшүүлсэн дурсгалт зүйлийн өмчлөгч, эзэмшигчтэй хамаарал бүхий этгээдийг оруулахыг хориглоно.

3.2.Шинжээчийн комиссын үйл ажиллагаанд баримтлах удирдамжийг Соёлын өвийн үндэсний төвийн захирал батална.

3.3.Соёлын өвийн үндэсний төв хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлсэн дурсгалт зүйлийн бүрэн бүрдэл бүхий баримт бичгийг байгууллагын цахим хуудаст ажлын 10-аас доошгүй өдөр байршуулж, олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулна.

3.4.Соёлын өвийн үндэсний төв нэр дэвшүүлсэн дурсгалт зүйлийн талаар дор дурдсан байгууллагаас санал авах ажлыг зохион байгуулна:

3.4.1.соёл, урлагийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

3.4.2.Шинжлэх ухааны академи;

3.4.3.түүх, соёл, урлагийн судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3-аас доошгүй эрдэм шинжилгээний байгууллага.

3.5.Соёлын өвийн үндэсний төв энэ журмын 3.3, 3.4-т заасан санал авах ажлыг зэрэг зохион байгуулж болно.

3.6.Соёлын өвийн үндэсний төв энэ журмын 2.5, 3.1, 3.3, 3.4-т заасны дагуу бүрдүүлсэн холбогдох баримт бичиг, санал, дүгнэлтийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.7.Соёлын өвийн үндэсний төвөөс ирүүлсэн хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлсэн дурсгалт зүйлийн талаарх асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэргэжлийн зөвлөл” (цаашид “Мэргэжлийн зөвлөл” гэх)-өөр хэлэлцүүлж, санал, дүгнэлт гаргуулна.

3.8.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлтэд үндэслэн, холбогдох шаардлагыг хангасан дурсгалт зүйлд хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

3.9.Энэ журамд заасан шаардлагыг хангаагүй тухай Мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлт гарсан бол дурсгалт зүйлийн баримт бичгийг Соёлын өвийн үндэсний төвд буцаан хүргүүлнэ.

3.10.Соёлын өвийн үндэсний төв буцаагдсан баримт бичгийг дурсгалт зүйлийн өмчлөгч, эзэмшигчид холбогдох тайлбарын хамт буцаан хүргүүлнэ.

Дөрөв.Бусад зүйл

4.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэл тогтоосон дурсгалт зүйлийн батламжийг өмчлөгч, эзэмшигчид гардуулах арга хэмжээг зохион байгуулна.

4.2.Хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэл тогтоосон дурсгалт зүйлийг олон нийтэд сурталчлах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний өмчлөгч, эзэмшигч болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулна.

4.3.Дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлсэн байдал болон холбогдох шаардлага хангаагүй талаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдлыг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 8 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 291

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

СОЁЛЫН САЙД

Ч.НОМИН

Засгийн газрын 2022 оны 291 дүгээр
тогтоолын хавсралт

**ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫГ УЛСЫН
ХАМГААЛАЛТЫН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ,
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар түүх, соёлын үл хөдлөх дурсгал (цаашид “дурсгал” гэх)-ыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх дурсгалыг судалгаа, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулж, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг бүрэн тодорхойлсон байна.

**Хоёр.Дурсгалыг улсын хамгаалалтын
зэрэглэлд нэр дэвшүүлэх**

2.1.Дурсгалыг оршин байгаа нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга өмчийн хэлбэр харгалзахгүй улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлнэ. Дурсгал хоёр ба түүнээс дээш аймгийн нутаг дэвсгэрийг дамнан оршиж байгаа бол дурсгалын ихэнх хэсэг байрлаж байгаа аймаг, нийслэлийн Засаг дарга бусад аймгийн Засаг дарга нартай зөвшилцөн нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулна.

2.2.Улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх дурсгал нь дараах шаардлагад нийцсэн байна:

2.2.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт байх;

2.2.2.түүхэн үйл явдлыг гэрчлэх, эсхүл өнгөрсөн үеийн нийгмийн хөгжлийн хувьсал, өөрчлөлтийг илэрхийлж чадах онцгой содон шинж, төрхийг хадгалсан байх;

2.2.3.ижил төрлийн дурсгалын нийтлэг хэв шинжийг хадгалсан сонгодог төлөөлөл байх;

2.2.4.эх төрх, бүрэн бүтэн байдал болон хүрээлэн буй орчны төлөв байдлаа хадгалсан байх;

2.2.5.газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, газар чөлөөлөхөөр ороогүй байх;



2.2.6. эрдэм шинжилгээний бүтээл, ном, сэтгүүлд хэвлэгдэх зэргээр олон нийтэд танигдсан байх;

2.2.7. аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлтэй байх.

2.3. Унаган газраас нь зөөж, аюулгүй орчинд шилжүүлэн байрлуулсан дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэхгүй.

2.4. Тодорхой газар нутаг, орон зайн ой санамжийг хамгаалах зорилгоор архивын баримтад үндэслэн боловсруулсан зураг төслийн дагуу анхны төрх байдлаар нь сэргээн босгосон дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлж болно.

2.5. Аймаг, нийслэлийн Засаг дарга хувийн өмчийн дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх бол хууль ёсны өмчлөгчтэй нь урьдчилан зөвшилцсөн байна.

2.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ журмын 2.2-т заасан шаардлагад нийцсэн дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх (цаашид “нэр дэвшүүлэх” гэх)-д дор дурдсан баримт бичгийг бүрдүүлэн Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлнэ:

2.6.1. нэр дэвшүүлэх үндэслэлийг тодорхой дурдсан санал бүхий албан бичиг;

2.6.2. энэ журмын 2.2-т заасан шаардлагад нийцсэн болохыг нотлох баримт;

2.6.3. дурсгалын түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг тодорхойлсон судлаач (доктор ба түүнээс дээш эрдмийн зэрэгтэй)-ийн тодорхойлолт;

2.6.4. дурсгалд хамгаалалтын бүс тогтоох урьдчилсан зураглал;

2.6.5. дурсгалыг хамгаалах, ашиглах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний урьдчилсан төлөвлөгөө;

2.6.6. энэ журмын 2.5-д заасан дурсгалын хувьд өмчлөгчийн санал;

2.6.7. дурсгалын гэрэл зураг, дүрс бичлэг, шаардлагатай бусад баримт.

Гурав.Саналыг хянан шийдвэрлэх

3.1.Соёлын өвийн үндэсний төв нэр дэвшүүлсэн дурсгал энэ журмын 2.2-т заасан шаардлагад нийцэж байгаа эсэх, мөн журмын 2.6-д заасан баримт бичгийн бүрдэл бүрэн эсэхийг хянаж, шаардлагад нийцээгүй, эсхүл баримт бичгийн бүрдэл дутуу тохиолдолд зөвлөмжийн хамт дурсгалыг нэр дэвшүүлсэн Засаг даргад буцаан хүргүүлнэ.

3.2.Соёлын өвийн үндэсний төв энэ журмын 2.2-т заасан шаардлагад нийцсэн, мөн журмын 2.6-д заасан бүрдэл бүрэн дурсгалын талаар танилцуулга бэлтгэж, дор дурдсан байгууллагаас санал авах ажлыг дурсгалыг нэр дэвшүүлэх саналыг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор зохион байгуулна:

3.2.1.соёл, урлагийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

3.2.2.Шинжлэх ухааны академи;

3.2.3.ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс;

3.2.4.дурсгалыг судлах, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3-аас доошгүй эрдэм шинжилгээний байгууллага;

3.2.5.дурсгалыг судлах, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3-аас доошгүй төрийн бус байгууллага.

3.3.Соёлын өвийн үндэсний төв энэ журмын 2.6-д заасан баримт бичиг болон 3.2-т заасан санал, танилцуулгыг нэгтгэн тухай бүр соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэр дэвшүүлсэн дурсгалыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 46.2-т заасан Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, санал, дүгнэлт гаргуулна.

3.5.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 3.4-т заасан санал, дүгнэлтийг үндэслэн тухайн дурсгалд улсын хамгаалалтын зэрэглэл тогтоох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

3.6.Дурсгал энэ журамд заасан шаардлагад нийцээгүй тухай санал, дүгнэлт гарсан тохиолдолд ирүүлсэн баримт бичгийг Соёлын өвийн үндэсний төвд буцаан хүргүүлнэ.



3.7.Соёлын өвийн үндэсний төв энэ журмын 3.6-д заасан баримт бичгийг нэр дэвшүүлсэн Засаг даргад холбогдох тайлбарын хамт буцаан хүргүүлнэ.

Дөрөв.Бусад зүйл

4.1.Эвдэрч, утсан дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлээс хасах асуудлыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

---оОо---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 8 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 296

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 3.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг энэ тогтоолын 1-д заасан журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Ашигт малтмал, газрын тосны газар (С.Баярмандал) нарт, журмын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж)-т, журмыг хэрэгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 151 дүгээр тогтоол, “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 355 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Г.ЁНДОН

Засгийн газрын 2022 оны 296 дугаар
тогтоолын хавсралт

БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Энэ журам нь ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтайгаас бусад төрлийн ашигт малтмалыг бичил уурхайгаар олборлох үйл ажиллагаанд хамаарна.

1.3.Энэ журмын зорилго нь үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй нөөц, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмалыг бичил уурхайгаар олборлох, байгаль орчныг хамгаалах, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино.

1.4.Бичил уурхай эрхлэгч этгээд нь Иргэний хуулийн 35.1-д заасан нөхөрлөл, 36.4-т заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд, мөн хуулийн 481.1-д заасан бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэртэй байна.

1.5.Нэг нөхөрлөл, хоршооны гишүүдийн тоо нь 9-өөс цөөнгүй байх бөгөөд гишүүн нь өөр нөхөрлөл, хоршоонд бүртгэлгүй байна.

1.6.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд өмнө нь хөндөгдөөгүй болон нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн газар ашиглуулахыг хориглоно.

Хоёр.Ашигт малтмал олборлох өргөдөл гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

2.1.Бичил уурхай эрхлэгч этгээд нь бичил уурхайгаар ашигт малтмал олборлохыг хүссэн өргөдлийг тухайн сум, дүүргийн Засаг даргад энэ журмын 1 дүгээр хавсралтад заасны дагуу гаргана.

2.2.Өргөдөлд бичил уурхайгаар ашигт малтмал олборлоход ашиглах техник хэрэгслийн гэрэл зураг, техникийн үзүүлэлтийг хавсаргасан байна.

2.3.Бичил уурхай эрхлэгч этгээд нь дараах шаардлагыг хангасан иргэнийг бичил уурхайд ажиллуулна:

2.3.1.18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн;

2.3.2.тухайн аймаг, нийслэлд оршин суугчаар бүртгүүлсэн;

2.3.3.нөхөрлөл, хоршооны гишүүн;

2.3.4.бичил уурхайн мэргэжлийн холбооны зохион байгуулсан бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нөхөн сэргээлтийн болон бичил уурхайгаар олборлох бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох сургалтад хамрагдан гэрчилгээ авсан;

2.3.5.харьяалах аймаг, нийслэлийн татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлсэн.

2.4.Энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангаагүй иргэнийг гишүүнээр авсан бичил уурхай эрхлэгч этгээдийн гаргасан өргөдлийг хүлээн авахгүй.

2.5.Сум, дүүргийн Засаг дарга нь энэ журмын 5.1.2-т заасны дагуу тусгай хэрэгцээнд авсан газрын шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан тухайн талбайд гаргасан өргөдлийн дарааллын дагуу бичил уурхай эрхлэгч этгээдтэй бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан загварын дагуу бичил уурхайн мэргэжлийн холбоотой хамтран байгуулна.

2.6.Энэ журмын 2.5-д заасан хугацаанд сум, дүүргийн Засаг дарга бичил уурхай эрхлэгч этгээдтэй гэрээ байгуулаагүй бол гэрээ байгуулаагүй үндэслэлээ өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

2.7.Энэ журмын 9.1.1-д заасан дүгнэлтээр бичил уурхайн зориулалтаар ашиглах боломжгүй нь тогтоогдвол тухайн сум, дүүргийн Засаг дарга бичил уурхай эрхлэгч этгээдэд мэдэгдэж, өргөдлийг буцаана.

2.8.Энэ журмын 2.3.4-т заасан сургалтын агуулга, хөтөлбөрийг төрийн захиргааны байгууллага, бичил уурхайн мэргэжлийн холбоо хамтран баталж хэрэгжүүлнэ.

Гурав.Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

3.1.Бичил уурхай эрхлэгч этгээд нь дараах эрхтэй байна:

3.1.1.бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын талаарх мэдээллийг сум, дүүргийн Засаг даргаас авах;

3.1.2.бичил уурхайгаар ашигт малтмал олборлохыг хүссэн өргөдөл гаргах;

3.1.3.бичил уурхайгаар ашигт малтмал олборлохыг хүссэн өргөдлийн бүртгэлийн дарааллаар сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулах;

3.1.4.гэрээ байгуулсан бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлохдоо 3500 см³ хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 1-ээс илүүгүй механизмыг ашиглах;

3.1.5.олборлосон ашигт малтмалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу борлуулах.

3.2.Бичил уурхай эрхлэгч этгээд нь дараах үүрэгтэй байна:

3.2.1.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, гишүүдийн бүртгэл, нөхөрлөл, хоршоо үүсгэн байгуулсан гэрээ, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ашигт малтмал олборлох талбайд байнга хадгалах;

3.2.2.нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг бичил уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн газарт нөхөн сэргээлт хийх аргачлал, загварын дагуу батлуулж, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээнд хавсаргасан байх;

3.2.3.гэрээгээр олгосон талбайг бусдад шилжүүлэхгүй, барьцаалахгүй, худалдахгүй, түрээслэхгүй байх;

3.2.4.бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх;

3.2.5.тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргаас тогтоож өгсөн талбайд амьдрах суурьшлын талбай, хог хаягдлын цэг байгуулах;

3.2.6.бичил уурхайн ажилтнуудыг нийгмийн даатгалд хамруулах, олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос хууль тогтоомжийн дагуу хувь хүний орлогын албан татвар суутгах;

3.2.7.тэсэлгээний ажлыг тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх;

3.2.8.олборлолтын талбайд 18 нас хүрээгүй иргэнийг оруулахгүй байх;

3.2.9.үйл ажиллагаанаас олсон орлогоос хуульд заасны дагуу татвар төлөх;

3.2.10.нөхөн сэргээлтийг бичил уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн газарт нөхөн сэргээлт хийх аргачлал, зааврын дагуу гүйцэтгэн, сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст актаар хүлээлгэн өгч, эвдрэлд орсон талбайн хэмжээ, нөхөн сэргээлтийн тайлан мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлж бүртгүүлэх;

3.2.11.тухайн жилийн үйл ажиллагааны тайланг сум, дүүргийн Засаг даргад дараа оны 1 дүгээр сарын 31-ний өдөрт багтаан хүргүүлэх;

3.2.12.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулахын өмнө Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах барьцаа хөрөнгийг тухайн сумын нөхөн сэргээлтийн дундын дансанд байршуулах;

3.2.13.ашигт малтмал олборлолт, борлуулалтын бүртгэлийг энэ журмын 7 дугаар хавсралтад заасны дагуу тогтмол хөтлөх;

3.2.14.бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа талбайд тэсэлгээний ажил явуулахаас бусад тохиолдолд туслан гүйцэтгэгчээр ажил гүйцэтгүүлэхгүй байх;

3.2.15.бичил уурхай эрхлэгч этгээд нь Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлсөн байх.

3.3.Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч этгээдэд тусгай зөвшөөрлийг олгох, бүртгэх, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, хяналт, хариуцлагатай холбогдсон харилцааг “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын дагуу Санхүүгийн зохицуулах хороо зохицуулна.

3.4.Бичил уурхай эрхлэгч этгээд нь дээрх журмын дагуу Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд олборлосон үнэт металл, үнэт чулуугаа борлуулна.



3.5.Бичил уурхай эрхлэгч этгээд нь Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авна.

Дөрөв.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбай

4.1.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох нэгж талбайн хэмжээ 5 га-аас ихгүй байна.

4.2.Сум, дүүргийн нутаг дэвсгэрт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн нийт хэмжээ 50 га-аас ихгүй байна.

4.3.Энэ журмын 5.1.2-т заасан шийдвэрийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга нь бичил уурхай эрхлэгч этгээдтэй энэ журмын 2 дугаар хавсралтад заасан загварын дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээг байгуулна.

4.4.Энэ журмын 4.3-т заасан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа бичил уурхай эрхлэгч этгээд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талбайгаас олборлосон ашигт малтмалыг борлуулахдаа ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр дээр бүртгүүлнэ.

Тав.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх, үүрэг

5.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах эрх, үүрэгтэй байна:

5.1.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн сум, дүүргийн Засаг даргын бичил уурхайн талаар авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тайланг сонсож чиглэл, зөвлөмж өгөх;

5.1.2.энэ журмын 8.1.3-т заасан дүгнэлтийг үндэслэн бичил уурхайн зориулалтаар газрыг тусгай хэрэгцээнд авах талаар гаргасан сум, дүүргийн Засаг даргын саналыг хэлэлцэн шийдвэрлэж, шийдвэрээ ажлын 10 өдөрт багтаан сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх.

Зургаа.Сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг

6.1.Сум, дүүргийн Засаг дарга дараах эрх, үүрэгтэй байна:

6.1.1.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох иргэдийг бүртгэж үнэмлэх олгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

6.1.2.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар бичил уурхай эрхлэгч этгээдийн гаргасан өргөдлийг үндэслэн өргөдөлд заасан талбайд дүгнэлт гаргуулах саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад уламжлах;

6.1.3.энэ журмын 5.1.2-т заасан шийдвэрийг үндэслэн өргөдөл гаргасан бичил уурхай эрхлэгч этгээдтэй бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээг бичил уурхайн мэргэжлийн холбоотой хамтран байгуулах;

6.1.4.бичил уурхай эрхлэгч этгээд нь гэрээгээр тогтоосон талбайн солбицлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;

6.1.5.нөхөн сэргээлт хийгээгүй болон ашигт малтмал олборлох гэрээний үүргээ биелүүлээгүй бичил уурхай эрхлэгч этгээдтэй байгуулсан гэрээг цуцлах, түүнтэй дахин гэрээ байгуулахгүй байх;

6.1.6.бичил уурхайн ажилтнуудыг нийгмийн халамжийн үйлчилгээ болон нийгмийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах;

6.1.7.нөхөн сэргээлт хийлгэж, нөхөн сэргээлт хийсэн талбайг комисс томилон хүлээж авах, энэ талаарх тайланг аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх;

6.1.8.бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих;

6.1.9.химийн хорт болон аюултай бодис, хориглосон химийн бодис хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавих;

6.1.10.бичил уурхайн эрхлэгч этгээдийн үйл ажиллагааны тайланг энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан загварын дагуу гаргаж, аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх;

6.1.11.бичил уурхай эрхлэгч этгээдийн суурьшлын талбайг тогтоох;

6.1.12.бичил уурхай эрхлэгч этгээд олборлолт явуулсан талбайг нөхөн сэргээж орон нутагт хүлээлгэн өгсөн тохиолдолд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг буцаан олгох;

6.1.13.сумын тусгай дансанд төвлөрүүлсэн бичил уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг тухайн талбайд зөвхөн зориулалтын дагуу зарцуулах;



6.1.14.нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө нь бичил уурхай эрхлэгч этгээдийн нөхөн сэргээлт хийлгүй орхисон талбайд нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлэхэд хүрэлцэхгүй тохиолдолд шаардагдах хөрөнгийг бичил уурхай эрхлэгч этгээдээс албадан гаргуулах;

6.1.15.энэ журмын 3.2.10, 3.2.11-д заасан хугацаанд тайланг ирүүлээгүй бичил уурхай эрхлэгч этгээдийн бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээг цуцлах;

6.1.16.гэрээнд заасан үүргээ биелүүлж ажилласан бичил уурхай эрхлэгч этгээдтэй тухайн талбайн ашигт малтмалыг ашиглаж дуусах хүртэлх хугацаанд гэрээг жил бүр сунгах;

6.1.17.ашигт малтмалын гарал үүслийн бүртгэл, бичил уурхай эрхлэгч этгээдийг чадавхжуулах үйл ажиллагааг дэмжин, мэргэжлийн холбоотой хамтран хариуцлагатай бичил уурхайг төлөвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

6.1.18. газар, ус ашиглах асуудлаар гэрээнд тусгах.

6.2.Бичил уурхайд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан комисс зохих журмын дагуу судлан бүртгэж, акт тогтоон тухайн аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт мэдэгдэнэ.

6.3.Төрийн захиргааны байгууллагаас дүгнэлт гаргаагүй талбайд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулахыг хориглоно.

6.4.Зөвхөн бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулсан этгээдэд энэ журмын 3.2.13-т заасан олборлолтын бүртгэлийг үндэслэн гарал үүслийн тодорхойлолт гаргаж өгнө.

Долоо.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх, үүрэг

7.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах эрх, үүрэгтэй байна:

7.1.1.аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой уялдуулан бичил уурхайн талаар авч хэрэгжүүлж байгаа Засаг даргын ажлын тайланг сонсож чиглэл, зөвлөмж өгөх.

Найм.Аймаг, нийслэлийн Засаг даргын эрх, үүрэг

8.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах эрх, үүрэгтэй байна:

8.1.1.бичил уурхайн үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

8.1.2.энэ журмын 6.1.2-т заасан талбайд дүгнэлт гаргуулах саналыг ажлын 10 хоногт багтаан хайгуул, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

8.1.3.энэ журмын 9.1.1-д заасан дүгнэлтийг сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх;

8.1.4.энэ журмын 5.1.2-т заасан шийдвэр, холбогдох мэдээллийг Ашигт малтмалын тухай хуулийн 14.1-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагад хүргүүлж бүртгүүлэх;

8.1.5.бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авсан газрын зураг зүйн бүртгэл болон бичил уурхай эрхлэгч этгээдийн талаарх нэгдсэн судалгаа бүхий мэдээллийн сан бүрдүүлж төрийн захиргааны болон холбогдох бусад байгууллагад хүргүүлэх, цахим хуудсаар мэдээлж байх;

8.1.6.бичил уурхай эрхлэгч этгээдийн үйл ажиллагааны тайланг энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу сум, дүүргээс авч нэгтгэн төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх;

8.1.7.бичил уурхай эрхлэгч этгээдийн үйл ажиллагааны талаарх сум, дүүргийн Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэн зөвлөмж, чиглэл өгөх;

8.1.8.бичил уурхай эрхлэгч этгээдийн үйл ажиллагааны талаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг холбогдох мэдээллээр хангах;

8.1.9.бичил уурхайн нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

8.1.10.бичил уурхайн осол, байгалийн болон давагдашгүй хүчин зүйлс, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд авран туслах үйл ажиллагааг цаг алдалгүй үзүүлэх, нийтийн хэв журам сахиулах арга хэмжээ авах;



8.1.11.бичил уурхайн ажилтнуудыг хөнгөлөлттэй зээл, төсөл, хөтөлбөрт хамруулах, бичил уурхайгаас бусад төрлийн ажлын байр бий болгож ажлын байраар хангах ажлыг зохион байгуулах.

Ес.Төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

9.1.Хайгуул, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах эрх, үүрэгтэй байна:

9.1.1.энэ журмын 8.1.2-т заасан саналыг хүлээн авч Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23-т заасан дүгнэлтийг ажлын 10 хоногт багтаан гаргаж, уг дүгнэлтэд холбогдох мэдээллийг хавсарган аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх ба шаардлагатай тохиолдолд газар дээр нь ажиллах;

9.1.2.бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрыг кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгэх;

9.1.3.бичил уурхайн ажилтнуудын судалгаа гарган мэдээллийн сан бүрдүүлж, өөрчлөлт хөдөлгөөний тайланг жил бүрийн I улиралд багтаан хайгуул, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

9.1.4.бичил уурхайн ажилтнууд, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын ажилтанд бичил уурхайтай холбогдсон хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал болон байгаль орчны нөхөн сэргээлтийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулах;

9.1.5.бичил уурхай эрхлэх боломжтой газрын судалгаа гаргаж, аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх;

9.1.6.энэ журмын 8.1.2-т заасан талбай нь Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.23-т заасан тодорхойлолттой нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргах.

Арав.Төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг

10.1.Хайгуул, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах эрх, үүрэгтэй байна:

10.1.1.Төрийн урт, дунд хугацааны бодлоготой уялдуулан бичил уурхайн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, нэгдсэн удирдлагаар хангах.

10.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах эрх, үүрэгтэй байна:

10.2.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээд болон бичил уурхайн мэргэжлийн холбоог бичил уурхайн байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн удирдлагаар хангах;

10.2.2.хүрээлэн буй орчны бохирдол доройтлыг бууруулах, байгалийн баялгийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;

10.2.3.бичил уурхай эрхлэгч этгээдийн нөхөн сэргээлтийн тайлан, талбайн нэгдсэн мэдээллийг санд бүртгэх.

Арван нэг.Бичил уурхайн мэргэжлийн холбооны эрх, үүрэг

11.1.Бичил уурхайн мэргэжлийн холбоо дараах эрх, үүрэгтэй байна:

11.1.1.сум, дүүргийн Засаг даргатай хамтран энэ журмын 1.4-т заасан бичил уурхай эрхлэгч этгээдтэй гэрээ байгуулах;

11.1.2.бичил уурхайчдад бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нөхөн сэргээлтийн болон бичил уурхайгаар олборлох бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох сургалтыг зохион байгуулах;

11.1.3.бичил уурхайчдад гэрчилгээ олгох;

11.1.4.бичил уурхай эрхлэгч этгээдийн гэрээний биелэлтэд тогтмол хяналт тавьж ажиллах;

11.1.5.гэрээ байгуулсан бичил уурхай эрхлэгч этгээд, бичил уурхай эрхлэгч этгээдийн нөхөн сэргээлт, олборлолтын бүртгэлийг хөтөлж, холбогдох төрийн байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллах;

11.1.6.ашигт малтмалын гарал үүслийн бүртгэл, хариуцлагатай бичил уурхайг төлөвшүүлэх талаар сум, дүүргийн Засаг даргатай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх.

Арван хоёр.Талбайг буцааж хүлээлгэн өгөх

12.1.Бичил уурхай эрхлэгч этгээд дараах тохиолдолд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайг буцаан хүлээлгэж өгнө:

12.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлөөс шалтгаалан олборлолтыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тухай эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлт гарсан;

12.1.2.талбайг цаашид ашиглах боломжгүйн улмаас хүлээлгэн өгөх хүсэлт гаргасан, гэрээг цуцалсан;

12.1.3.гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, гэрээг талууд дүгнэсэн.

12.2.Энэ журмын 12.1-д заасны дагуу талбайг буцаан хүлээлгэж өгсөн нь бичил уурхай эрхлэгч этгээдийн өөрийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт байгаль орчны нөхөн сэргээлт хийх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Арван гурав.Хяналт тавих, хариуцлага хүлээлгэх

13.1.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилтэд нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, төрийн захиргааны байгууллага, бичил уурхайн мэргэжлийн холбоо хяналт тавина.

13.2.Энэ журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 1 дүгээр хавсралт

(Энэхүү өргөдлийг гаргацтай, засваргүй бичиж бөглөнө үү)

..... аймгийн сум, дүүргийн
Засаг дарга /..... / Танаа

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох өргөдөл гаргах нь:

..... оны ... сарын ... өдөр



“.....” нөхөрлөл, хоршоог төлөөлж..... албан тушаалтай
(оноосон нэрийг бичих)
..... овогтой..... -аас.....
. аймаг (хот) - ийн..... сум (дүүрэг)-ын нутаг дэвсгэрт
байршилтай..... нэртэй талбайд.....
..... олборлох өргөдөл гаргаж байна.
(ашигт малтмалын төрөл)

Өргөдлийг хянан үзэж, бүртгэж, шийдвэрлэж өгнө үү.

Өргөдөлд дараах бичиг баримтыг хавсаргав. Энэ зайг өргөдөл хүлээн
авагч бөглөнө.

- | | |
|--|---|
| 1. Үүсгэн байгуулсан гэрээ, дүрмийн хуулбар | 1 |
| 2. Бичил уурхайчдын үнэмлэхийн хуулбар | 1 |
| 3. Нөхөрлөл буюу хоршооны улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар | 1 |
| 4. Олборлолт явуулах талбайн байршлын зураг | 1 |
| 5. Бичил уурхайчдын албан татвар төлөгчийн бүртгэлийн дэвтрийн хуулбар | 1 |
| 6. Бичил уурхайчдын нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар | 1 |
| 7. Тухайн талбайг сонгосон үндэслэл, тайлбар | 1 |
| 8. Бичил уурхайн нөхөрлөлийн гишүүдийн “Бичил уурхайн үндсэн сургалтад хамрагдсан гэрчилгээ” | |

Өргөдөл гаргасан:..... /
/гарын үсэг/ /овог, нэр/

Өргөдлийг хүлээн авсан тухай тодорхойлолт:

Өргөдлийг 20... оны ... сарын ... өдрийн цаг минутад хүлээн авч өргөдлийн бүртгэлийн дугаарт бүртгэв.

Өргөдлийг хүлээн авч, бүртгэсэн ажилтан..... /
/гарын үсэг/ /овог, нэр/

Бичил уурхайгаар ашигт малтмал
олборлох журмын 2 дугаар хавсралт

БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ТУХАЙ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 2.1, 3.1.3, 6.1.3-т заасны дагуу нэг талаас

..... аймаг (хот)-ийн сум (дүүрэг)-ын Засаг дарга (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас “.....” нөхөрлөл, хоршоо (цаашид “Бичил уурхай эрхлэгч этгээд” гэх)-ийг төлөөлж (албан тушаал), гуравдагч талаас Бичил уурхайн мэргэжлийн холбоо (цаашид “Холбоо” гэх)-ны гүйцэтгэх захирал нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 20.... оны дугаар сарын-ны өдөр энэхүү гэрээг (цаашид “Гэрээ” гэх) сум (дүүрэг)-нд байгуулав.

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Бичил уурхай эрхлэгч этгээд нь сум (дүүрэг)-ын нэртэй газарт орших гектар талбайд журмын 6.1.3-т заасны дагуу жилийн хугацаагаар (ашигт малтмалын төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхэлнэ.

1.2.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум (дүүрэг)-ын Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

Хоёр.Сум (дүүрэг)-ын Засаг даргын эрх, үүрэг

2.1.Сум (дүүрэг)-ын Засаг дарга нь “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1.бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож, байршлын зургийг гэрээнд хавсаргах;

2.1.2.хог хаягдлын цэгийн байршлыг тогтоох;

2.1.3.бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайг тогтоох;

2.1.4.бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдтэй тохиролцсоны үндсэн дээр зохих хөрөнгийг сумын нөхөн сэргээлтийн дундын дансанд төвлөрүүлэх;

2.1.5.бичил уурхайн ажилтнуудад (цаашид “ажилтан” гэх) зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг Холбоотой хамтран зохион байгуулах;

2.1.6.энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах;

2.1.7.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих;

2.1.8.хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох;

2.1.9.бичил уурхай эрхлэгч этгээд олборлолт явуулсан талбайг нөхөн сэргээж орон нутагт хүлээлгэн өгсөн тохиолдолд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг буцаан олгох;

2.1.10.бичил уурхай эрхлэгч этгээдийн бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу хийж, сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст актаар хүлээлгэн өгсөн талбайн мэдээлэл, нөхөн сэргээлтийн тайлан мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж бүртгүүлэх.

Гурав.Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

3.1.Бичил уурхай эрхлэгч этгээд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах;

3.1.2.ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах;

3.1.3.суурьшлын талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдлын цэгийг байгуулах;

3.1.4.гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо бус этгээдийг ажиллуулахгүй байх;

3.1.5.байгаль орчныг хамгаалж, гол, горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх;



3.1.6.бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.1.7.хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт, сурталчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах;

3.1.8.ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх;

3.1.9.үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглахгүй байх;

3.1.10. Иргэний хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см³ хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах;

3.1.11.бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах / / төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх;

3.1.12.нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах;

3.1.13.бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийж сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэж өгөх, актаар хүлээлгэн өгсөн талбайн мэдээлэл, нөхөн сэргээлтийн тайлан мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж бүртгүүлэх;

3.1.14.олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээд, Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд олборлосон үнэт металл, үнэт чулууг худалдах;

3.1.15.ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар төлөх.

3.2.Бичил уурхай эрхлэгч этгээд нөхөн сэргээлт хийж, талбайд хүлээлгэн өгсний дараа ашигт малтмал олборлох өргөдөл дахин гаргах.

Дөрөв.Мэргэжлийн холбооны үүрэг

4.1.Төрийн захиргааны байгууллага, сум, дүүрэгтэй хамтран баталсан хөтөлбөрийн дагуу Бичил уурхайн үндсэн сургалтын хөтөлбөрийн дагуу бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, ашигт малтмалын гарал үүсэл, магадлан шинжилгээ, нөхөн сэргээлтийн сургалтыг нөхөрлөлийн гишүүдэд зохих журмын дагуу зохион байгуулах, гэрчилгээ олгох.

4.2.Бичил уурхайчдад гэрчилгээ олгох.

4.3.Энэхүү гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж гэрээний хэрэгжилтийн үнэлгээг жил бүр хийх, хэрэгжилтийн үнэлгээний мэдээллийг Ашигт малтмал газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлэх.

Тав.Маргаан шийдвэрлэх

5.1.Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

5.2.Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

Зургаа.Гэрээний хүчин төгөлдөр болох

6.1.Энэхүү гэрээ нь 20.... оны сарын өдрөөс 20 оны сарын өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.2.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

6.3.Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Долоо.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.1.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

7.2.Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

Гэрээ байгуулсан:

..... аймаг (хот)-ийн сум (дүүрэг)-ын Засаг дарга

/...../

/эцэг/эх/-ийн нэр, нэр,

/...../

гарын үсэг/

/тамга, тэмдэг/

“.....” (нөхөрлөл, хоршоо) төлөөлж

/...../

/эцэг/эх/-ийн нэр, нэр,

/...../

гарын үсэг/

/тамга, тэмдэг/

Бичил уурхайгаар ашигт малтмал
олборлох журмын 3 дугаар хавсралт

**АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙГААС
БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ
ГУРВАЛСАН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 4.3 дахь заалтын дагуу нэг талаас..... аймаг (хот)-ийн сум (дүүрэг)-ын Засаг дарга (цаашид “Засаг дарга” гэх) нөгөө талаас тус сум (дүүрэг)-ын нэртэй газарт ашигт малтмал ашиглах дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) “.....” компанийн захирал гуравдагч талаас “.....” нөхөрлөл, хоршоо (цаашид “Бичил уурхай эрхлэгч этгээд” гэх)-ийг төлөөлж (албан тушаал) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) харилцан тохиролцож 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр энэхүү гурвалсан гэрээ (“Гэрээ” гэх)-г аймаг (хот)-т байгуулав.



Нэг.Ерөнхий зүйл

1.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн талбайгаас бичил уурхай эрхлэгч этгээдэд (ашигт малтмалын төрөл) олборлох зориулалтаар талбай ашиглуулахтай холбогдон Засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

1.2.Энэхүү гэрээг 20.... оны сарын өдрөөс эхлэн жилийн хугацаагаар байгуулав.

Хоёр.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг

2.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1.тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн дор дурдсан солбицол бүхий цэгүүдийг холбосон шугамаар хүрээлэгдсэн гектар талбайг бичил уурхай эрхлэгч этгээдэд ашиглуулах;

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1
2
3
4
5

2.1.2.бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайн байршлыг тогтоох;

2.1.3.бичил уурхай эрхлэгч этгээдийн гэрээнд заасан солбицлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;

2.1.4.бичил уурхай эрхлэгч этгээдийн аюулгүй байдлын дүрмийн мөрдөлтөд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг авах;

2.1.5.бичил уурхай эрхлэгч этгээдэд нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэхэд нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

2.1.6.бичил уурхай эрхлэгч этгээд болон Засаг даргаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

2.1.7.бичил уурхай эрхлэгч этгээдээс тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байхыг шаардах;



2.1.8.бичил уурхай эрхлэгч этгээд нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, уурхайн хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тухай саналыг талуудад гаргах;

2.1.9.бичил уурхай эрхлэгчдийн татвар, даатгалтай холбоотой асуудлыг хариуцахгүй байх;

2.1.10.гэрээт талбайгаас олборлосон ашигт малтмалыг худалдахдаа тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр дээр бүртгүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах;

2.1.11.бичил уурхай эрхлэгч этгээдийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг гэрээ байгуулсан өдрөөс хойш 1 сарын дотор геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.

Гурав.Сум (дүүрэг)-ын Засаг даргын хүлээх эрх, үүрэг

3.1.Сум (дүүрэг)-ын Засаг дарга нь Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.бичил уурхайн ажилтнуудад (цаашид “ажилтан” гэх) “Бичил уурхайн аюулгүй байдлын дүрэм”-ийг таниулах, ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд анхан шатны тусламж үзүүлэх, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагаар сургалт хийлгэх ажлыг зохион байгуулах;

3.1.2.хог хаягдлын цэгийн байршлыг тогтоох;

3.1.3.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих;

3.1.4.тусгай зөвшөөрөл эзэмшигч болон бичил уурхай эрхлэгч этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

3.1.5.бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу эрх бүхий хуулийн этгээдэд борлуулж байгаа эсэхэд хяналт тавих;

3.1.6.бичил уурхай эрхлэгч этгээд болон тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

3.1.7. талууд гэрээний үүргээ биелүүлээгүй, бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөөгүй тохиолдолд бичил уурхай эрхлэгч этгээдийн ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зогсоож, талуудад гэрээг цуцлах тухай санал гаргах;

3.1.8. хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүргээ хэрэгжүүлэх.

Дөрөв. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

4.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1. гэрээт талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулах;

4.1.2. гэрээгээр олгосон талбайд зөвхөн бүртгэлтэй гишүүнийг ажиллуулах;

4.1.3. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;

4.1.4. сум (дүүрэг)-ын Засаг даргаас тогтоосон суурьшлын талбайд амьдрах, тогтоосон газарт хог, хаягдлын цэг байгуулах;

4.1.5. олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах ажлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тогтоосон талбайд болон төвлөрсөн баяжуулах цехэд гүйцэтгэх;

4.1.6. гэрээт талбайн ашигт малтмалын нөөцийг бүрэн гүйцэд ашиглах;

4.1.7. бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, ослоос урьдчилан сэргийлэх;

4.1.8. ашигт малтмалын олборлох үйл ажиллагаанд химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ашиглахгүй байх;

4.1.9. байгаль орчныг хамгаалж, голын горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх, нөхөн сэргээлт хийх;

4.1.10. ажилтнуудын дунд холбогдох хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах;



4.1.11.олборлосон ашигт малтмалыг эрх бүхий этгээдэд борлуулахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр дээр бүртгүүлэх;

4.1.12.холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар төлөх, бичил уурхайчдыг нийгмийн даатгалд хамруулах;

4.1.13.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг тусгай зөвшөөрөл эзэмшигч болон Засаг даргаас шаардах;

4.1.14.хууль тогтоомжийг мөрдөх, нийгмийн хэв журмыг сахин биелүүлэх.

Тав.Харилцан хүлээх үүрэг

5.1.Гэрээг цуцлах үндэслэл бий болсон тохиолдолд талуудад гэрээг цуцлах тухай саналаа бичгээр хүргүүлнэ.

5.2.Гэрээнд талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлан хамтарч ажиллана.

5.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч, эсхүл бичил уурхай эрхлэгч этгээдийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчин, бусад этгээдэд хохирол учирвал уг хохирлыг буруутай тал барагдуулна.

Зургаа.Маргаан шийдвэрлэх

6.1.Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

6.2.Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд үүссэн маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Долоо.Гэрээний хүчин төгөлдөр болох

7.1.Энэхүү гэрээ нь 20... оны ... сарын ... өдрөөс 20... оны ... сарын ... өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2.Гэрээний хүчинтэй хугацаанд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд гэрээ хүчингүй болно.

7.3.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 3.2.10-т заасны дагуу орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.



7.4.Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах талаарх саналаа аль нэг тал нөгөө талууддаа бичгээр мэдэгдсэн боловч нөгөө талууд нь ажлын 20 хоногт багтаан асуудлыг шийдвэрлээгүй, эсхүл хариу өгөөгүй тохиолдолд гэрээ хүчингүй болно.

7.5.Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Найм.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

8.1.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

8.2.Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

Гэрээ байгуулсан:

..... аймаг (хот)-ийн сум (дүүрэг)-ын Засаг дарга
/...../ /...../
/эцэг/эх/-ийн нэр, нэр, гарын үсэг, тамга, тэмдэг/

“.....” компанийг төлөөлж
/...../ /...../
/эцэг/эх/-ийн нэр, нэр, гарын үсэг, тамга, тэмдэг/

“.....” нөхөрлөл, хоршоог төлөөлж
/...../ /...../
/эцэг/эх/-ийн нэр, нэр, гарын үсэг, тамга, тэмдэг/

“.....” Бичил уурхайн мэргэжлийн холбоог төлөөлж
/...../ /...../
/эцэг/эх/-ийн нэр, нэр, гарын үсэг, тамга, тэмдэг/

Бичил уурхайгаар ашигт малтмал
олборлох журмын 4 дүгээр хавсралт

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧ ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ГАРГАХ ЗАГВАР

Аймаг	Сум	Тайлбарын тусгай зөвшөөрлийн дугаар	Солбицол	Олборлолт явуулж байгаа байрны хэмжээ (га)	Ашиглалт Ил Дэлд	Нөхөрлөл, хоршоо		Үүнээс		Үүнээс		Үүнээс		Бичил уурхайн овог, нэр, релазацийн дугаар	Олборлолт явуулж эхэлсэн хэсэг, хэмжээ, төлбөрийн талбай (га)	Нөхөн сэргээлт хийсэн талбай (га)	Бичил уурхайн ослын мэдээ					
						Бичил уурхай эрхлэгч этгээдийн нэр	Газар байршил олборлолт эхэлсэн огноо	Гялшуйлын тоо	эр эм	банга	үлсрийн чандартай иргэд	Бичил уурхайн овог, нэр, релазацийн дугаар	Нэгжид хүрсэн хүүгс					Журам зөрчиж 18 хүртэлх насны хүүхэд амжилуулсан эсэх				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	

Тайлан гаргасан: Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын
..... /албан тушаалт/..... /овог, нэр, гарын үсэг, тамга, тэмдэг /



Бичил уурхайгаар ашигт малтмал
олборлох журмын 5 дугаар хавсралт

БИЧИЛ УУРХАЙН ХҮДЭР ОЛБОРЛОЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

Бичил уурхайн нөхөрлөл/хоршооны нэр:
Аймаг/сум:

№	Хүдэр олборлосон огноо	Хүдэртэй, Шуудайны тоо	Нийт жин (кг)	Ажилласан хугацаа (цаг)	Ажилласан хүний тоо	Тэмдэглэл хөтөлсөн хүний овог, нэр	Гарын үсэг
1							
2							
3							
4							
5							
6							
7							
8							
9							
10							
11							
12							
13							
14							
15							
16							
17							
18							
19							
20							
21							
22							
23							
24							
25							
26							
27							
28							
29							
30							



Бичил Уурхайгаар ашигт малтмал
олборлох журмын 6 дугаар хавсралт

20... оны ... сарын ...-ны өдөр

№ аймаг СУМ

БИЧИЛ УУРХАЙН ХҮДРИЙН ГАРАЛ ҮҮСЛИЙН БАТАЛГААЖИЛТЫН ХУУДАС

..... бичил уурхайн нөхөрлөл/хоршооны олборлосон ширхэг шуудай, ТОНН
машины дугаартай марктай хүдрийн гарал үүслийг баталгаажуулан, нэртэй хүдэр боловсруулах
үйлдвэрээр хүдэр баяжуулахыг зөвшөөрөв.

Хүчинтэй хугацаа: 20 оны сарын өдөр хүртэл

..... бичил уурхайн нөхөрлөл/ хоршооны ахлагч
/...../



Бичил уурхайгаар ашигт малтмал
олборлох журмын 7 дугаар хавсралт

20 ... оны ... сарын ... өдөр Бичил уурхайгаар олборлосон алтны баталгаажилтын хуудас	20 ... оны ... сарын ... өдөр Бичил уурхайгаар олборлосон алтны баталгаажилтын хуудас
Бичил уурхайн хүдрийн гарал үүслийн баталгааны хуудасны дугаар	Бичил уурхайн хүдрийн гарал үүслийн баталгааны хуудасны дугаар
Хүдрийн хэмжээ	Хүдрийн хэмжээ
Бүртгэсэн: Цехийн төлөөлөгч, (Нэр, гарын үсэг, тамга)	Бүртгэсэн: Цехийн төлөөлөгч, (Нэр, гарын үсэг, тамга)
Баяжуулсан алтны хэмжээ	Баяжуулсан алтны хэмжээ
Хүлээлгэн өгсөн: Баяжуулах цехийн лабораторийн ажилтан (нэр, гарын үсэг)	Хүлээлгэн өгсөн: Баяжуулах цехийн лабораторийн ажилтан (нэр, гарын үсэг)
Хүлээн авсан: Бичил уурхайн нөхөрлөл/хоршооны ахлах (нэр, гарын үсэг)	Хүлээн авсан: Бичил уурхайн нөхөрлөл/хоршооны ахлах (нэр, гарын үсэг)
Худалдан борлуулсан: Үнэт металл, үнэт чулууны худалдаа эрхлэгч (нэр, байгууллага, гарын үсэг, тамга)	Худалдан борлуулсан: Үнэт металл, үнэт чулууны худалдаа эрхлэгч (нэр, байгууллага, гарын үсэг, тамга)

---000---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 9 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар 345

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 288.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Батлагдсан журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Х.НЯМБААТАР

Засгийн газрын 2022 оны 345 дугаар
тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИД МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал (цаашид “мөнгөн урамшуулал” гэх) олгоход энэ журмыг баримтална.

1.2.Аймгийн төвөөс бусад суманд ажиллаж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч энэ журамд заасан мөнгөн урамшуулал авах эрх нь 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн үүснэ.

Хоёр.Мөнгөн урамшуулал олгоход тавигдах шаардлага

2.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч (цаашид “алба хаагч” гэх) аймгийн төвөөс бусад нэг буюу хэд хэдэн сумдад тасралтгүй 60 сар ажилласан бол түүнд таван жил тутам нэг удаа мөнгөн урамшуулал олгоно.

2.2.Сумын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас аймгийн төв болон нийслэлд шилжин ажиллаж байгаад суманд эргэн томилогдсон бол өмнө нь ажиллаж байсан хугацааг нэмж тооцохгүй бөгөөд тухайн суманд томилогдсон өдрөөс эхлэн хугацааг шинээр тоолно.

2.3.Мөнгөн урамшууллыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө тухайн суманд ажиллаж байгаад аймгийн төв болон нийслэлд, бусад байгууллагад шилжин ажилласан, халагдсан, тэтгэвэрт гарсан алба хаагчид олгохгүй.

Гурав.Мөнгөн урамшууллын хэмжээг тодорхойлох

3.1.Мөнгөн урамшуулал олгох хугацааг аймгийн төвөөс бусад суманд томилогдсон өдрөөс эхлэн тасралтгүй ажилласан 60 сарын хугацаагаар тооцох бөгөөд тасралтгүй ажилласан 60 сар гэж дараах хугацааг ойлгоно:

3.1.1.суманд томилогдсон цагаас шилжилт хөдөлгөөн хийлгүй 60 сар ажилласан хугацааг;

3.1.2.сум хооронд шилжин ажилласан хугацааны нийлбэр нь 60 сар болсон.

3.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 286.7-д заасан нэмэгдлийг энэ журмын 3.1-д заасан хугацаанд оруулан тооцохгүй.

3.3.Мөнгөн урамшууллын хэмжээ нь тухайн алба хаагчийн сүүлийн 60 сарын хугацаанд эрхэлж байсан албан тушаалын үндсэн цалингийн дунджийг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

Дөрөв.Мөнгөн урамшуулал олгох

4.1.Энэ журмын 2.1-д заасан шаардлага хангасан алба хаагч мөнгөн урамшуулал авах хүсэлтээ өөрийн ажиллаж байгаа байгууллагын удирдах албан тушаалтанд бичгээр гаргана.



4.2.Энэ журмын 4.1-д заасан удирдах албан тушаалтан алба хаагчийн хүсэлтийг жил бүрийн 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагад дараах баримтын хамт хүргүүлнэ:

4.2.1.тухайн алба хаагчийг томилсон шийдвэрийн хуулбар;

4.2.2.сүүлийн 60 сард эрхэлж байсан албан тушаалын цалингийн тодорхойлолт;

4.2.3.шаардлагатай тохиолдолд бусад баримт бичиг.

4.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага тухайн алба хаагчийн ажилласан хугацаа, албан тушаалын сарын үндсэн цалинг үнэн зөв тодорхойлох үүрэгтэй.

4.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага энэ журмын 4.2-т заасны дагуу ирүүлсэн баримт, бичгийг хянаж, баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан мөнгөн урамшуулал олгох эсэх шийдвэрийг гаргана.

4.5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргын мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг үндэслэн урамшууллын мөнгийг тухайн алба хаагчийн дансанд шилжүүлнэ.

4.6.Энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангаж, мөнгөн урамшуулал авах хүсэлт гаргасан алба хаагч нас барсан тохиолдолд мөнгөн урамшууллыг түүний гэр бүлд нь олгоно.

Тав.Бусад

5.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага аймгийн төвөөс бусад сумдад ажиллаж байгаа энэ журамд заасан мөнгөн урамшуулал авах шаардлага хангасан алба хаагчдын тоо, түүнд шаардагдах зардлын тооцоо, судалгааг жил бүр гарган хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.2.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас ирүүлсэн мөнгөн урамшуулал олгох алба хаагчдын тоо, түүнд шаардагдах хөрөнгийн тооцоог үндэслэн дараа жилийн улсын төсөвт тусган батлуулах арга хэмжээ авна.

5.3.Албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалин болон ажилласан хугацааг буруу тодорхойлох, хуурамч баримт бичиг бүрдүүлэх зэргээр мөнгөн урамшууллыг хууль бусаар тогтоож олгосон албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

--000--



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 9 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 352

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.19-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” Засгийн газрын 2009 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 143 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД**

Н.УЧРАЛ

Засгийн газрын 2022 оны 352 дугаар
тогтоолын хавсралт

НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БАЙЛГАХ БОЛОН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОГТООХ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журам нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д заасан нийтийн мэдээлэл хариуцагч (цаашид “мэдээлэл хариуцагч” гэх) мөн хуулийн 8.2-8.6-д заасан нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг тогтоох, 8.17-д заасан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл” (цаашид “Зөвлөл” гэх) нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Мэдээлэл хариуцагч нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангахад Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ыг мөрдөнө.

1.3.Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийхэд дараах зарчмыг баримтална:

- 1.3.1.шударга, хараат бус байх;
- 1.3.2.үнэлгээ нь нээлттэй, олон нийтийн оролцоог хангасан байх;
- 1.3.3.үнэлгээний тайлан, дүгнэлт нь ил тод байх;
- 1.3.4.үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, мэдээ тайланд үндэслэсэн байх;
- 1.3.5.зөвлөмж нь ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн байх;
- 1.3.6.ил тод байдлын тайлан нь үнэн зөв, нотлогдохуйц байх;
- 1.3.7.үнэлгээний тайланд тусгагдсан мэдээллийн үнэн зөв байдлыг мэдээлэл хариуцагч хариуцдаг байх.

Хоёр.Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлт

2.1.Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

2.1.1.мэдээллийн хүртээмжтэй байдал-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 8.8-д заасны дагуу олон нийтэд ил тод мэдээлсэн эсэх;

2.1.2.хугацаандаа нийтлэгдсэн байдал-нээлттэй мэдээллийг хуулийн 8.9, 8.11-д заасан хугацаанд олон нийтэд хүргэсэн эсэх;

2.1.3.мэдээллийн бүрэн бүтэн байдал-нээлттэй мэдээллийг хуулийн 8.2-8.6-д заасан зохицуулалтын хүрээнд бүрэн гүйцэд тусгасан эсэх;

2.1.4.эх сурвалжийн тодорхой байдал-хуулийн нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эх сурвалж, холбоо барих мэдээллийг цахим хуудсанд байршуулсан эсэх.

Гурав.Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийх аргачлал

3.1.“Мэдээллийн хүртээмжтэй байдал”-ыг (МХБ) дараах аргачлалаар үнэлнэ:

3.1.1.нээлттэй мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлсэн бол ХАНГАЛТТАЙ буюу 30 оноо;

3.1.2.нээлттэй мэдээллийг ДУТУУ буюу зөвхөн цахим хуудагт нийтэлсэн бол 15 оноо, мэдээллийн самбарт нийтэлсэн бол 10 оноо, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлсэн бол 5 оноо;

3.1.3.нээлттэй мэдээллийг нийтлээгүй бол ХАНГАЛТГҮЙ буюу 0 оноо.

3.2.“Хугацаандаа нийтлэгдсэн байдал”-ыг (ХНБ) дараах аргачлалаар үнэлнэ:

3.2.1.нээлттэй мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд нийтэлсэн, шинэчилсэн бол ХАНГАЛТТАЙ буюу 30 оноо;

3.2.2.нээлттэй мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанаас хойш нийтэлсэн, шинэчилсэн бол ДУТУУ буюу 10 оноо;

3.2.3.нээлттэй мэдээллийг нийтлээгүй, шинэчлээгүй бол ХАНГАЛТГҮЙ буюу 0 оноо.

3.3.“Мэдээллийн бүрэн бүтэн байдал”-ыг (МБББ) дараах аргачлалаар үнэлнэ:

3.3.1.хуулиар 8.6-д заасан мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээгээгүй мэдээлэл хариуцагчийн хувьд хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 30 оноо, дутуу нийтэлсэн бол 15 оноо;

3.3.2.хуулийн 8.6-д заасан мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээсэн мэдээлэл хариуцагчийн хувьд хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 15 оноо, дутуу нийтэлсэн бол 10 оноо, хуулийн 8.6-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 15 оноо, дутуу нийтэлсэн бол 5 оноо;

3.3.3.хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан нээлттэй мэдээллийг нийтлээгүй бол 0 оноо.

3.4.“Эх сурвалжийн тодорхой байдал”-ыг (ЭСТБ) дараах аргачлалаар үнэлнэ:

3.4.1.нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эрх бүхий ажилтны харьяалах нэгжийн нэр, албан тушаал, нэр болон холбоо барих мэдээллийг нийтэлсэн бол ХАНГАЛТТАЙ буюу 30 оноо;

3.4.2.энэ журмын 3.4.1-д заасан мэдээллийн аль нэгийг нийтлээгүй бол ДУТУУ буюу 10 оноо;

3.4.3.энэ журмын 3.4.1-д заасан мэдээллийг нийтлээгүй бол ХАНГАЛТГҮЙ буюу 0 оноо.

3.5.Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хувийг шалгуур үзүүлэлтийн оноонд үндэслэн дараах аргачлалаар тооцож гаргана:

$$\text{Хэрэгжилтийн хувь} = \left(\frac{\text{МХБ} + \text{ХНБ} + \text{МБББ} + \text{ЭСТБ}}{120} \right) * 100$$

3.6.Үнэлгээний ерөнхий болон хэсгийн дундаж оноо, хувийг үзүүлэлтүүдийн оноо, хувийн арифметик дунджаар тооцно.

Дөрөв.Нээлттэй мэдээллийн ил тод байдалд үнэлгээ хийх удирдлага, зохион байгуулалт

4.1.Мэдээлэл хариуцагч өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод байдлыг энэ журмын 3 дугаар зүйлд заасан аргачлалаар үнэлж, “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хүснэгт”-ийн дагуу гаргах бөгөөд үнэлгээний тайланг салбарын хэмжээнд сайд, нутаг дэвсгэрийн хэмжээнд аймаг, нийслэлийн Засаг дарга нэгтгэж, бусад мэдээлэл хариуцагч жил бүрийн 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор Зөвлөлийн ажлын албанд тоон гарын үсгээр баталгаажуулан цахим хэлбэрээр хүргүүлнэ.

4.2.Зөвлөлийн ажлын алба нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний тайланг хүлээн авч, үнэлгээг энэ журмын 3 дугаар зүйлд заасан аргачлалын дагуу хийгдсэн эсэхийг хянах бөгөөд үнэлгээнд өөрчлөлт оруулж болно.



4.3.Зөвлөлийн ажлын алба үнэлгээний цахим мэдээллийн сан үүсгэж, үнэлгээний тайлан, үнэлгээнд оруулсан өөрчлөлтийн талаарх мэдээллийг байршуулна.

4.4.Зөвлөлийн ажлын алба үнэлгээний нэгдсэн тайланг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангаагүй мэдээлэл хариуцагчид зөвлөмж хүргүүлнэ.

----oOo----

“Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хавсралт

НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ

№	Нээлттэй мэдээлэл	Шалгуур үзүүлэлтийн оноо				Хэрэгжилтийн хувь
		МХБ	ХНБ	МБББ	ЭСТБ	
Нэг.Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал						
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн					
1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг					
1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж					
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан					
1.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан					



1.6	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт					
1.7	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг					
1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ					
1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл					
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр					
Дундаж оноо, хувь						
Хоёр.Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал						
2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл					
2.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам					
2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм					
2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам					
2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ					
2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам					
Дундаж оноо, хувь						
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал						
3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл					
3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан					
3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт					



3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ					
3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар					
3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг					
3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт					
3.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр					
3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл					
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендэрт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендэрт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан					



3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт					
3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл					
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн					
3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан					
3.15	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хязгаарласан этгээдийн жагсаалт					
3.16	Засгийн газрын гадаад улс, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн гэрээ, хэлэлцээрийн талаарх мэдээлэл					
3.17	Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлт					
3.18	Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээлэл					
3.19	Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээлэл					
3.20	Улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар					
3.21	Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ					
3.22	Төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан					



3.23	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээлэл					
3.24	Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт					
3.25	Концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл					
3.26	Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээлэл					
3.27	Улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоо					
3.28	Орон нутгийн төсвийн төсөлд санал авах талаарх хэлэлцүүлгийн мэдээлэл					
Дундаж оноо, хувь						
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал						
4.1	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл					
4.2	Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа					
Дундаж оноо, хувь						



Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал						
5.1	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал					
5.2	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт					
5.3	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл					
5.4	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл					
5.5	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг					
5.6	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл					



5.7	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьд нэгдсэн төсөв болон Үндэсний баялгийн санд оруулж байгаа татвар, хөрөнгийн хэмжээ					
5.8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл					
5.9	Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл					
5.10	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны зрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл					
5.11	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт					
5.12	Тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт олгосон газар ашиглах гэрчилгээ, байгуулсан гэрээ, газар ашигласны төлбөр төлөлтийн байдал					



5.13	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ					
5.14	Шүүн таслах ажиллагааны дүн мэдээ					
5.15	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу маргаан хянан шийдвэрлэсэн ажиллагааны дүн мэдээ					
5.16	Улс төрийн намын дүрэм, гишүүнчлэл, хөрөнгө, түүнд өгсөн хандивын мэдээлэл					
5.17	Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, хүргүүлсэн тайлан, Монгол Улсад өгсөн зөвлөмж, зөвлөмжийн хэрэгжилтийг хариуцах байгууллагын талаарх мэдээлэл					
5.18	Зүй ёсны монополь аж ахуй эрхлэгчийн үнийн бүрдлийн мэдээлэл болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийн жагсаалт					
5.19	Хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл					
5.20	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт					



5.21	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан					
5.22	Албан тушаалтны Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар					
5.23	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт					
5.24	Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэл					
5.25	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл					
Дундаж оноо, хувь						
Үнэлгээний ерөнхий оноо, хувь						

Нэмэлт мэдээлэл гаргах байгууллага:

Энэ хавсралтын 3.15, 3.16, 3.17, 3.18, 3.19, 3.20, 3.21, 3.22, 3.23, 3.24, 3.25, 3.26, 3.27, 5.7-д заасан мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 5.9, 5.12-т заасан мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 5.14-т заасан мэдээллийг Монгол Улсын Дээд шүүх, 5.15-д заасан мэдээллийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, 5.16-д заасан мэдээллийг улс төрийн нам, 5.17-д заасан мэдээллийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 5.18-д заасан мэдээллийг өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 5.19-д заасан мэдээллийг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус гаргана.

--о0о--



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2022 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 11.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Солонго, Б.Буяндэлгэр, Ц.Нанзаддорж, Ж.Эрдэнэбулган /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Э.Түмэнбаяр, Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нар оролцов.

Энэхүү хуралдаанаар Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Монгол Улсын иргэн Э.Түмэнбаяр Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталсан Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт “Хуульчийг дараах тохиолдолд өмгөөлөгчийн шалгалтад оруулахаас татгалзана.” гээд 8.6.3 дахь заалтад “энэ хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил, албан тушаал эрхэлж байгаа,” гэж хуульчилжээ.

Өөрөөр хэлбэл, хууль зүйн чиглэлээр багшлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, өмгөөллийн хуулийн этгээд, мэргэжлийн холбоо, түүний хороодын чиг үүрэгт хамаарахаас бусад ажил, албан тушаал хашиж байгаа болон улс төрийн нам, түүний харьяа, салбар, бүтцийн нэгжид орон тооны ажил, албан тушаал хавсран эрхэлж буй хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах гэрчилгээтэй иргэн өмгөөлөгчийн шалгалтад

оролцохын тулд эрхэлж буй ажлаасаа чөлөөлөгдөх шаардлага үүсэхээр байна. Улмаар чөлөөлөгдөөд шалгалтад оролцоод тэнцвэл өмгөөлөгчийн эрх олж авна, шалгалтад тэнцээгүй тохиолдолд ажилгүй үлдэх нөхцөл байдал үүсэж байна.

Мөн хүнийг эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлаж улмаар ажлаа чөлөөтэй сонгох эрхийг нь хязгаарласан гэж үзэж байна. Энэ нь эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж байна гэж үзэхээр байна.

Харин шалгалтад тэнцсэн хуульч өмгөөлөгчийн эрх авч өмгөөлөгч болох уу, эрхэлж буй ажлаа үргэлжлүүлэн хийх үү гэдгээ өөрөө сонгох эрхтэй байх ёстой. Хэрэв өмгөөллийн эрхээ авах бол өмнөх ажлаасаа чөлөөлөгдсөн байх талаар Өмгөөллийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Өмгөөлөгчдийн Холбоо энэ хуулийн 7.2-т заасан хүсэлтийг ажлын 10 өдрийн дотор хянаж, энэ хуулийн 8.6-д заасан нөхцөл байдал илрээгүй тохиолдолд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох саналыг Монголын Өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгч/цаашид “Өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгч” гэх/-д хүргүүлнэ.”, мөн зүйлийн 7.4 дэх хэсэгт “Өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгч энэ хуулийн 7.3-т заасан саналыг үндэслэн хуульчийг өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэлд бүртгэж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгоно.” гэж тус тус хуульчилжээ.

Иймд Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтад “энэ хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил, албан тушаал эрхэлж байгаа,” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтад “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасныг зөрчсөн гэж үзэж байна. Иймд маргаан үүсгэж, хянан шийдвэрлэж өгнө үү.” гэсэн агуулга бүхий мэдээлэл ирүүлсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Үндсэн хуулийн цэцэд хандан гаргасан тайлбартаа:

“1.Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй.” гэж, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Хуульд заасан бөгөөд үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун буюу бусдын эрх, эрх чөлөө болон энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн бусад эрхийг хамгаалахад шаардлагатай хязгаарлалтаас бусдаар дээр дурдсан эрхийг хязгаарлаж болохгүй.” гэж, мөн Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Захиргааны зөвлөлөөс 1958 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталж, 1960 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон /Монгол Улс 1969 оны 5 дугаар сарын 10-ны өдөр соёрхон баталсан/ Алагчилахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 111 дүгээр конвенцын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (а) заалтад “алагчилах” гэсэн нэр томъёог “арьс үндэс, арьсны өнгө, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, үндэс угсаа буюу нийгмийн гаралд үндэслэн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн салбарт тэгш боломж, хандлагыг үгүйсгэх буюу зөрчихөд хүргэж байгаа аливаа ялгаварлах, хавчин гадуурхах, эсхүл давуу байдал олгох үйлдэл;” хэлнэ гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Тодорхой ажлын онцлогтой холбоотой тавигдах шаардлагад үндэслэсэн ялгаварлах, хавчин гадуурхах, эсхүл давуу байдал олгох үйлдлийг “алагчилах” хэмээх ойлголтод хамааруулахгүй.” гэж тус тус заасан.

Өөрөөр хэлбэл, Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад зааснаар ардчилсан нийгэмд хүний эрхийг хамгаалах үндсэн зарчмын хүрээнд зайлшгүй нөхцөл байдал үүссэн, бусад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгын үүднээс гагцхүү хуулиар хүний эрхийг хязгаарлахыг төрд зөвшөөрсөн байдаг тул Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсгийг зөрчсөн гэж үзэх боломжгүй байна.

2.Өмгөөллийн тухай хуулиар өмгөөллийн үйл ажиллагаанд хавсран эрхэлж болохгүй албан тушаалыг тусгайлан заасан нь өмгөөллийн үйл ажиллагааг хараат бусаар эрхлэх боломжийг бий болгох зорилтын хүрээнд хууль тогтоогч энэхүү хязгаарлалтыг тусгаж өгсөн. Тухайлбал, өмгөөлөгч нь төрийн албан тушаалыг хавсран эрхэлсэн тохиолдолд шүүн таслах үйл ажиллагаанд нийгмийн бүхий л салбарт ажиллаж, амьдарч байгаа этгээдийн хууль ёсны төлөөлөгч болохын хувьд албан тушаалтны нөлөөнд автах эсхүл ажил, албан тушаалаар дамжуулан нөлөөлөх, давуу байдал үүсгэх зэрэг эрсдэлийг үүсгэнэ гэж үздэг.

Түүнчлэн, өмгөөлөгч нь бусад ажил, албан тушаал хавсран эрхлэх нь үйлчлүүлэгчид үзүүлэх цаг зав болон боломж нь багасах эрсдэлтэй гэж үздэг. Өөрөөр хэлбэл, өмгөөлөгч нь хүний амь нас, эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, эд хөрөнгө зэрэг хувь хүний үнэтэй бүхнийг хамгаалдаг ажил мэргэжлийн хувьд үйлчлүүлэгчийнхээ төлөө бүхий л боломжоо дайчлан ажиллах ёстой байтал бусад ажил, албан тушаал хавсран гүйцэтгэх нь үйлчлүүлэгчийн ашиг сонирхол хөндөгдөх эрсдэлтэй гэж тооцсон.

Гэсэн хэдий ч иргэн Э.Түмэнбаяр мэдээлэлдээ “өмгөөлөгч болох хүсэлтэй бөгөөд хуульд заасан шаардлагыг хангасан бүх хуульч өмгөөлөгчийн шалгалтад оролцох эрх нээлттэй бөгөөд гагцхүү өмгөөлөгчийн эрх авах үедээ хуулиар зөвшөөрөөгүй бусад ажил, албан тушаалыг хавсран эрхлэхгүй байх агуулгаар хуулийг батлах ёстой байсан. Шалгалтад тэнцсэн хуульч өмгөөлөгчийн эрх авч өмгөөллөөр ажиллах эсхүл эрхэлж буй ажлаа үргэлжлүүлэн ажиллах эсэхээ өөрөө сонгох эрхтэй байх ёстой. Хэрэв өмгөөллийн эрхээ авах бол өмнөх ажлаасаа чөлөөлөгдсөн байх талаар Өмгөөллийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсгүүдэд тус тус хуульчилжээ.” гэж дурдсан нь үндэслэлтэй байна.

Иймд Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт нь Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан байх магадлалтай тул хууль тогтоох бүрэн эрхийнхээ хүрээнд уг асуудлыг засаж залруулах боломжтой гэж үзэж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталсан Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлд өмгөөлөгчийн шалгалтын талаарх зохицуулалтыг хуульчилж, мөн зүйлийн 8.6 дахь хэсэгт хуульчийг өмгөөлөгчийн шалгалтад оруулахаас татгалзах үндэслэлийг тусгасан байна. Уг хэсгийн 8.6.3 дахь заалтад “энэ хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил, албан тушаал эрхэлж байгаа;” буюу хууль зүйн чиглэлээр багшлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, өмгөөллийн хуулийн этгээд, мэргэжлийн холбоо, түүний хороодын чиг үүрэгт хамаарахаас бусад ажил, албан тушаал хавсран эрхэлж байгаа, эсхүл улс төрийн нам, түүний харьяа, салбар, бүтцийн нэгжид орон тооны ажил, албан тушаал хавсран эрхэлж байгаа хуульчийг өмгөөлөгчийн шалгалтад оруулахгүй байхаар хуульчилжээ.

Өмгөөллийн тухай хуулийн дээрх заалт нь тухайн мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан тавьсан нийтлэг хязгаарлалт байх бөгөөд эрх зүйн байдлын хувьд адил тэгш этгээдүүдэд зүй бус ялгаварлал, алагчилсан байдал үүсгэсэн гэж үзэх үндэслэлгүй байна.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч маргааныг шалгах явцад ирүүлсэн тайлбар болон Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт нь Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан байх магадлалтай гэж хүлээн зөвшөөрсөн болно.

Мөн Өмгөөллийн тухай хуулийн зохицуулалт хоорондын уялдааг зохистой хангах, хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх хууль зүйн баталгааг сайжруулах зорилгоор тус хуулийг боловсронгуй болгох нь зүйтэй гэж Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын бүрэлдэхүүн үзлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:

1.Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтад “энэ хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил, албан тушаал эрхэлж байгаа,” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

2.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Д.ОДБАЯР

ГИШҮҮД

**Ш.СОЛОНГО
Б.БУЯНДЭЛГЭР
Ц.НАНЗАДДОРЖ
Ж.ЭРДЭНЭБУЛГАН**



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: tugui_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 4.75

Индекс: 200003